

ТӨВ АЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ДИПЛОМАТ

ЁС ДАХЬ МАЛЫН ҮҮРЭГ

Проф.доктор /Sc.D/ М.Хурметхан
Олон Улс Судлалын Хүрээлэн. ШУА,

Монгол Улс

Төв Азийн нүүдэлчидийн бүхий л амьдрал материаллаг болон оюуны соёл, аж төрөх ёс, нийгмийн харилцаа нь мал аж ахуйд үндэслэн бүрэлдэн хөгжиж багтсан байдаг. Тэгээд тэдний орчин цагийн амьдралыг аль ч талаас нь авч үзсэн ч гэсэн яг цав мэргэжсэн малчин харагдана. Малаа гэсэн энэрэл болон мал маллах явцад бүрэлдсэн ёс зүй болон зан заншил нь тэдний хөдөлгөөн, хүмүүнлэг чанар, дипломат ёс нь бүрэлдэн бий болох үндэс, төв нь байлаа. Төв Азийн нүүдэлчидийн хувьд байгаль орчин, хүн, мал, түүх, зан заншил, уламжлал ,сэтгэхүй зэрэг нь өөр хоорондоо үл тайлагдахаар зангигдсан тогтвортой үзэгдэл юм. Тэгээд ч Төв Азийн нүүдэлчидийн амьдралд таван хошуу мал шийдвэрлэх байр суурьтай байдаг бөгөөд тэдний өдөр тутмын амьдралаас авахуулаад төрийн өндөр хэмжээний дипломат ёсонд хүртэл холбоотой байдаг билээ.

Төв Азийн нүүдэлчидийн сонгомол төлөөлөгчид болох монгол, казахын ард түмний түмний аль аль нь ихээхэн зочиломтгой бөгөөд энэ нь ахуйн мөн чанараас эхтэйгээр бүрэлдэн бий болжээ. Эдгээр ард түмнүүд улс хоорондын харилцаанд эрхэм хүндэт зочиддоо хамгийн хүндэт бэлгэн болгон агт морьд, мал өгч, хүндэтгэлийн эрхэм сэтгэлээ мөн малын гаралтай амт шимт сайхан, байгалийн цэвэр бүтээгдэхүүнээр дамжин илэрхийлдэг уламжилалтай билээ. Тухайлбал: Билгэ хаан хятадын эзэн хаанд 50 хүлэг мориндоо бэлэг болгон илгээж байв./1/ Алтан ордны Бэрх хаан Египетийн элч нарыг айраг, чанасан мах зэргээр дайлж байсан /2/ зэрэг нүүдэлчдийн төр улсуудын дипломат ёсонд мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг төрийн дипломат ёсны үйл ажиллагаанд өргөн ашигладаг, өөрийн гэсэн дэг жаятай байсан тухай түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн зэргийг тоймгүй олон билээ./3/

Төв Азийн нүүдэлчин ард түмнүүдийн энэхүү уламжлал нь өнөөгийн үед уламжлагдан ирсэн төдийгүй шинэ агуулага, хэлбэрээр баяжиж байгаа юм. Ялангуяа таван хошуу малын нэг нь болох адуугаа тэд мал сүргийн манлай хэмээн хүндэлж, унахад хөнгөн, уралдахад хурдан, сүү нь эм болдог, сүр жавхлан нь их тул төрийн дипломат ёсонд өргөн ашиглаж байна. Монгол Улс, БНКазУ-д адууны айраг, махаар төрийн хүндэт зочдыг дайлж, хурдан морины уралдаан, морь ургалах, көкпар, кызкуар

зэргийг сониргуулан, хүлэг сайн агт морьд, морины иж бүрэн тоноглол зэргийг хүндэт зочиддоо бэлэглэн хүндэтгэлийн гүн сэтгэгдлээ илэрхийлдэг юм. Энд өөр нэгэн тэмдэглэх зүйл бол бэлэглэж байгаа малын өнгө зүс бас чухал байдаг юм. Казах үндэстэнд адуу бол амьдралынхаа бүх салаа салбарт цор ганц хэмжүүр бөгөөд бүхий л зүйлийг адуугаар баримжлан хэмжиж, түүгээр дээд хүндэтгэлээ үзүүлнэ. Мөн тэмээ ч хүндэтгэлмйн бэлэг болдог.

Төв Азийн нүүдэлчин ард түмнүүдийн хүндэтгэлийн зоогийн дээж малын мах, сүү, бусад бүтээгдэх нь болдог. Нүүдэлчдийн эртнээс нааш мал маллаж, ахуйд голлон шүтэж амьдралаар ирсэн тул төрийн дипломат ёсондоо хэрэглэх идээ ундаандаа ихэвчлэн малын сүү шим, махыг янз бүрийн аргаар боловсруулан дайлдаг.

Энэ нь монгол үндэстний төрийн хүндэтгэлд нь хүндэт зочинд мөнгөн аягатай сүүг хадгийн хамт өргөн барьж, өлзийтэй сайхан ерөөлөө дэвшүүлж байгаагаар илэрхийлдэг. Хүндэтгэлийн дайлаганд айраг, идээ /зүсмэл хурууд, тогооны өрөм/, хүнд шүүст- бүхэл мах, бууз, ордог билээ. Зочиныг онцлон хүндэтгэж хонины ууц, хоёр хажууд нь мөч мах зэрэгцүүлж тавьдаг. Ууцны толгой талыг зочин руу хандуулан дайвар махыг зөв өрсөн байна. Зочин хүн заншлын дагуу зочилуулагч хүнээс эхлэн тэнд байгаа бүх хүмүүст ууцны баруун зүүн талаас зүсэж дайллагын хишигт гэж түгээн өгдөг заншилтай. Монголчууд хамгийн хүндэт зочиндоо хонины ууц чанаж тавьдаг нь хонины махыг хамгийн эрхэм дээд чанартай гэж үнэлж үздэгийнх билээ.

Казах үндэстний төрийн хүндэтгэлийн дипломат ёсонд нь мөн малын мах, сүү гол үүрэгтэй юм. Хүндэт зочдыг малын сүүгээр хийсэн аруул, бяслаг, эзгий орсон идээ цагааны бэлэг цацал өргөн угтаж, өлзийтэй сайхан ерөөлөө дэвшүүлж байгаагаар илэрхийлдэг. Хүндэтгэлийн дайллаганд айраг, хонины толгой, мөч мах зэрэг ордог. Дастарханд /идээний дэвсрэг/ хамгийн хүндэт зочноо эсвэл хамгийн өндөр настаныг хоймрот суулгана. Казахын дипломат ёсонд табак тарту зочидод зоог барих ёс хамгийн чухал байдаг. Зочинд үзүүлж буй хүндэтгэл нь зочинд зориулсан нийт тавгийн тоо, хүндэт зочинд зориулсан таваганд орсон махаар дамжин илэрнэ. Хамгийн хүндэт зочинд барьсан тавагт- хонины хуйхалсан толгой, махтай сүүж, сүвээ, нуруу, 2-3 хавирга, казы /адууны сүвээний хиам/, жал /адууны дэлний өөх/, жая /хондлойн мах/, карта /адууны бүүдүүн гэдэс/, гэдэс орно. Хуйхалсан толгойг тогоонд шүдтэй нь хийдэг бөгөөд шүдийг авах нь хүүхэд залууст гай зовлон тохиолдоно гэж үздэгтэй холбоотой. Хүндэтгэлийн тавгийг зочиндоо тавихаас өмнө толгойн хуйхыг + хэлбэрээр зүсэж, тэндээ нэг зүсэм мах тавина. Толгойг хүндэт зочин руу хандуулан тавихад хамгийн хүндэт зочин ерөөл хэлээд, баруун талын завьжинаас огтлон өөрөө идээд, дараа нь бусад

хүмүүст толгойн баруун зүүн талаас зүсэж дайлагын хишигт гэж түгээн өгдөг заншилтай.Толгойн чихийг тэнд байгаа хүүхэдэд өгнө. Зочин бас хооллох завсараа мөн дайлагын махнаас хишигт хүртээж болно. Энэ нь огтолсон 3 ширхэг махаас хэтрэх ёсгүй. Эртний заншлаар үүнээс илүү хишиг хүртснээс болж хүн хахаж үхвэл, хишиг хүртээсэн хүн үхсэн хүнд ор босгон 100 адуу төлдөг заншилтай холбоотой.Мах идээж дууссаны дараа сорпа -шөл өгнө. Ерөөл тавьсанаар дайллага дуусна.

Даяарчилалын үед олон улсын харицаа өргөжиж байна. Төв Азийн нүүдэлчдийн мал төвтэй дипломат ёс дэгийн гүн утга агуулагыг дэлхийн бусад ард түмэн тэр бүр бүрэн гүцээд ойлгохгүй байгаа явдал харагддаг. Тэд үүнийг хэлбэрийн төдий сонирхохоос гадна заримдаа бишүүрхэх явдал ч гаргадаг.

Үүнээс үзэхэд Төв Азийн нүүдэлчин ард түмнүүдийн төрийн дипломат ёс дэг нь мал төвтэй соёлд тулгуурлан бүрэлдэж, батжин хөгжижээ. Мөн өнөөгийн үед бүрэн хэрэглэгдэн өөрийн гүн агуулага, өвөрмөц байдлаар төрийн дипломат ёсонд хүндтэй байр эзэлж байна. Гэхдээ ,даяарчлалын өнөөгийн үед Төв Азийн нүүдэлчдийн мал төвтэй дипломат ёсыг хадгалан хөгжүүлэх, орчин үежүүлэх, дэлхийн олон нийтэд сурталчилан таниулах, хэрэглэх хүрээг нь улам боловсронгуй болгох нь шаардлагатай байна.

1. Э.Шефер.Золотые персики Самарканда. “Наука” Москва.1981.с.30
2. 2. Н.Ишжамц, М.Хурметхаан. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа УБ.1995.т.138
3. Григорьев. Монгольская дипломатика XIII-XIV вв. М., 1978. Карпини П. История Монголов Спб 1911, Марко Поло Орчлонгийн элдэв сонин .УБ.1987, Гийомде Рубрук Монголын эзэнт гүрэнд зорчсон нь .УБ.2000.